



ДАРХАН-УУЛАЙМАГ  
ОРХОН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн төлөвлөгөөний 2021 оны 06 сарын 14 өдрийн 5311 дугаарт баталсан

2021 оны 04 сар 22 өдөр

Дугаар 03

Орхон

Малын тоо толгойн албан татварын  
хэмжээг тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "д", 18.2, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Тус суманд тоологдож бүртгэгдсэн малчин, мал бүхий иргэдийн өмчилж буй малын тоо толгойд албан татварын хэмжээг тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа төрөл тус бүр 2000 /хоёр мянган/ төгрөгөөр тогтоосугай.

2.Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн дагуу татвар ногдуулалт, бүрдүүлэлтийг хуулийн хугацаанд зохион байгуулж, тайлагнахыг сумын Засаг дарга /Б.Алтансарнай/, Татварын улсын байцаагч /Б.Гансүх/ нарт үүрэг болгосугай

3.Энэ тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дарза дагаж мөрдөн, олон нийтэд сурталчилан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Алтансарнай/, Татварын улсын байцаагч /Б.Гансүх/ нарт даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай. 16



С.Рагдоржиев

ДАРГА

*Б.Хулан*

Б.ХУЛАН



Дугаар 786



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ОРХОН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 55

Орхон

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 22 дугаар зүйлийн 22.1.4, 22.1.15, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалтыг тус тус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн 13 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Тус сумын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний хураамжийн хэмжээг айл, өрх сар бүр 8000 /найман мянган/ төгрөгөөр тогтоосугай.

2.Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн эрх үүргийн дагуу тогтоосон үйлчилгээний хураамжийг хугацаанд нь бүрэн төлж байхыг иргэн, айл, өрхөд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа дагаж мөрдөн, олон нийтэд сурталчилан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Түмэнцогт/-д даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн 2021 оны 20/04 тоот тогтоолыг 1 дэх заалтын айл өрх сар бүр 3000 (гурван мянган) төгрөг гэсэн заалтыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Б.АЛТАНСАРНАЙ

252201030

